



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Өлзийт сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БНА-2019/11/СТА-ТТЗ

Баянхонгор хот. 2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 7044-2584      Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 7044-2424      Цахим хаяг: tsetsegmaad@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Должмаа

Утас: 88119345      Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

---

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан .....	5
	2.1. Оршил.....	5
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	6
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	7
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	8
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	8
	2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	8
	2.8.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар .....	9
	2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар .....	10
	2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	10
	2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	11
	2.11. Шилэн дансны мэдээлэл .....	11
	2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	11
	2.13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:.....	12
	2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	12
3	Менежментийн захидал .....	14
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	16
	4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	16
	4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	17
	4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	21
	4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	24
	4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	24

---

## 1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум  
Утас, факс 70-44-25-84  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2019.03.25 № 2/130  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т  
Аудитын гэрчилгээ

ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Д.ЦЭДЭНСОДНОМ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2, 8.9.3-т заасны дагуу Өлзийт сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### **Зөрчилгүй санал дүгнэлт**

Өлзийт сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### **Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Өлзийт сумын Засаг даргын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

2519284


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг хариуцлага**

Өлзийт сумын Засаг дарга нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

## 2 Аудитын тайлан

### 2.1. Оршил

Өлзийт сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Сумын Засаг дарга Д.Цэдэнсодномд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2,3-д заасны дагуу Өлзийт сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлзийт сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.03.22-наас 2019.03.24-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.03.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор Б. Должмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Өлзийт сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019.03.05-ны өдөр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Өлзийт сумын Засаг даргын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Өлзийт сумын Засаг дарга нь “Оновчтой бодлого зохицуулалтаар хангах замаар иргэн бүр амьдарч байгаа орчиндоо сэтгэл хангалуун байх нийгэм, эдийн засгийн аятай нөхцлийг бүрдүүлэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Өлзийт сумын Засаг даргын удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Бага, дунд боловсролын тухай хууль
- Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байхгүй.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 8 байгууллага, нэгж 2018 оны санхүүгийн тайландаа аудит хийж баталгаажуулахаас 8 байгууллага аудитад хамрагдсан байна.

Төрийн аудитын байгууллагаас Өлзийт сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр				
		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрлэсэн	Итгэл үзүүлсэн	Гэрээгээр хийлгэсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	3	3	0	2	0
2	ТБӨӨААН	0	0	0	0	0
	Дүн	3	3	0	2	0

## 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Өлзийт сумын Засаг даргын харьяа байгууллагуудын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Өлзийт сумын Засаг даргын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Өлзийт сумын төсөвт байгууллагууд санхүүгийн тайланг бэлтгэхдээ "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн Acoulous 4.01, цалингийн Payroll программаар, харин санхүүгийн нэгтгэсэн тайланг Э-тайлан” програм хангамж ашиглаж бэлтгэсэн байна.

Өлзийт сумын Засаг даргын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод Үр нөлөөгүй гэж үзлээ.

Өлзийт сумын Засаг даргын дэргэд дотоод аудитын алба байхгүй байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд төрийн аудитын байгууллагаас хяналт шалгалт хийж, зөрчил илрээгүй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Өлзийт сумын Засаг даргын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, мөнгөн дүн 1 тэрбум төгрөгөөс дээш дүнтэй тул зардлын дүнгийн 1 хувиар сонгов.

Өлзийт сумын Засаг даргын 2018 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 2689326,1 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 26893,3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн шатанд шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг байдал илрээгүй.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн материаллаг биш боловч цаашид санхүүгийн тайлан, тодруулгад материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй зарим асуудлыг толилуулж байна.

Өлзийт сумын Засаг дарга болон төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагчийн хэмжээнд 96207,6 мянга, төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэмжээнд

10000,0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, сумын ЗДТГ-т илэрсэн 71066,9 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулав.

Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлыг хэрхэн ангилж, шийдвэрлэсэн байдлыг энэ тайлангийн 2.13-т нэгтгэсэн байдлаар үзүүлэв.

Асуудлыг өмнөх түвшинд хийсэн аудитын явцад гарсан асуудал, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад түүвэрт хамрагдсан асуудлаас илэрсэн асуудал гэсэн ангилалаар үзүүлэв. Үүнд:

### **2.8.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар**

#### **Асуудал 1: Зардлын данстай холбоотой асуудал**

Сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгийн тодруулгын тайлангийн дүнгээс тооллогын бүртгэлийн дүн 52324,8 мянган төгрөгөөр, бараа материалын дүн тооллогын бүртгэлээс 18742,1 мянган төгрөгөөр, нийт хөрөнгийн дүн 71066,9 мянган төгрөгөөр зөрүүтэй.

**Шийдэл:** Хөрөнгийн тооллогыг чанартай гүйцэтгэж, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан маягтуудыг бүрэн хөтөлж байх зөвлөмжийг өгсөн.

#### **Асуудал 2: Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт**

Аудитаар сум хөгжүүлэх сангаас зээл авсан 7 зээлдэгч 16950,0 мянган төгрөгийн зээлийг хугацаанд нь төлөөгүй хугацаа хэтрүүлж, зээлийн гэрээг зөрчсөн.

**Шийдэл:** Төлбөрийн акт тогтоосон.

**Асуудал 3:** Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж, хүлээн авсан тоног төхөөрөмжийг хөрөнгийг орлогод авах шийдвэр гараагүй байхад сумын Соёлын төвийн нягтлан бодогч 5 сумын хөрөнгийн дүнгээр хөрөнгөд орлогод авсан.

**Шийдэл:** Холбогдох шийдвэрийг үндэслэн 2019 онд орлогод авах зөвлөмж өгсөн.

**Асуудал 4:** Сумын Соёлын төв нийгмийн даатгалын массиваар 19,4 мянган төгрөгийн өглөгтэй ба сумын НДХ-ийн байцаагчтай нийлсэн тооцоо нийлсэн актаар үлдэгдэлгүй байна.

**Шийдэл:** Мэргэжлийн байгууллагатай тооцоог тухай бүр хийж, авлага, өглөггүй ажиллах зөвлөмж өгсөн.

**Асуудал 5:** Сумын ЗДТГ-ын тайлант онд акталсан үндсэн хөрөнгийг ИТХ-ын тогтоолтой тулган шалгахад 2017.11.01-ний өдөр ЗДТГ-ын дарга М.Батаа Баянлиг сумын ЗДТГ-ын дарга Г.Мөнхсүхтэй гэрээ байгуулж, байгууллагын эзэмшилд байсан, акталсан Кама маркын хогны автомашиныг 4.0 сая төгрөгөөр худалдах, худалдан авах гэрээ байгуулж, 2017.12.31-ний өдөрт багтааж, төлбөрийг төлөхөөр тохиролцсон боловч 2017.12.22-ны өдөр 3.0 сая төгрөг төлж, үлдэгдэл 1.0 сая төгрөгийг төлөөгүй байхад авлагаар бүртгээгүй, 2018 онд төлүүлээгүй байна.

**Шийдэл:** Төлбөрийн акт тогтоосон.

**Асуудал 6:** Өлзийт сумын ЗДТГ-ын нярав бусад хангамжийн бараа материалын тайлан гаргаагүй байхад нягтлан бодогч 2018.06.30-нд 5020.0 мянган төгрөгийн үтрэмийн будаа, 6950.8 мянган төгрөгийн тэжээлийн хивэг, 4162.5 мянган төгрөгийн өвс, нийт 16133.3 мянган төгрөгийн бараа материалыг зарлагадсан байна. Сумын ОНХС-ийн дансанд өвс, тэжээлийн орлогоор 17206.4 мянган төгрөг орж, зарлагадсан өвс тэжээлийн үнээс 1070.8 мянган төгрөгөөр зөрсөн бөгөөд үүний учрыг тодруулан шалгахад 2016 онд 6500.0 мянган төгрөгөөр 1100 боодол өвс авсныг орлогод аваагүй зарлагадснаас хүмүүсээс нийт 7190.7 мянган төгрөгийн авлага үүссэн байхад түүнийг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй зөрчил завсрын аудитаар илэрсэн.

**Шийдэл: Төлбөрийн акт тогтоосон.**

### 2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгээгүй болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	10000.0	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	2	10000.0	

### 2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй.

## **2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Өлзийт сумын Засаг даргын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой сумын ИТХ-ын хуралдаанаар 8 байгууллагын 16 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2046054,6 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн орлогын нийт гүйцэтгэл 1994896,1 мянган төгрөг буюу 97,5 хувь, зардлын нийт гүйцэтгэл 1906381,1 мянган төгрөг буюу 93,1 хувьтай байгаа нь Соёлын төв 1 орон тоо хэмнэснээс цалингийн зардал, ОНХС дээр 10,0 сая төгрөгийн ажил хэрэгжүүлээгүйгээс энэ дүнгээр хөрөнгийн зардал хэмнэгдсэн. СХС-аас 181,0 сая төгрөгийн зардал гарахаар төлөвлөсөн боловч эргэн төлөлт хангалтгүй орж, тайлант онд 60,0 сая төгрөгийн зардал гарсан байна.Цэцэрлэг шинэ байранд орж, 9-12 сард халаалтын зардал төлөхөөр төлөвлөсөн боловч 12 сард байр ашиглалтад орсноос халаалтын зардал хэмнэгдсэн байна. Байгаль хамгаалах сангийн зардал хэмнэгдсэн бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 1,3 сая төгрөгөөр хэмнэгдсэнээс шалтгаалжээ.

Сумын татварын орлогоор 83199,2 мянган төгрөг оруулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 97828,5 мянган төгрөг оруулж, төлөвлөгөөг 14029,3 мянган төгрөгөөр давуулан биелүүлжээ.

Төсвийн орлого, зардлын төлөвлөгөөний биелэлтийг харьяа байгууллагаар нь авч үзвэл Соёлын төв өөрийн үйл ажиллагааны орлогоор 2000,0 мянган төгрөг төлөвлөснөөс 798,5 мянган төгрөг оруулж, сургууль 500,0 мянган төгрөгийн орлого оруулахаас түрээсийн орлогоор 125,0 мянга, ЗДТГ 600,0 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 2210,0 мянган төгрөгийн орлого оруулжээ.

## **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Өлзийт сумын Засаг дарга Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Сумын Засаг даргын 2018 оны 04 дүгээр улирлын байдлаарх шилэн дансны цахим хуудаст тавьсан мэдээллийг хангалттай хэмжээнд оруулсан байна.

## **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Сумын Засаг даргын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар зөвлөмж өгөөгүй байна.

### 2.13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Өлзийт сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгээгүй бөгөөд нийт илэрсэн алдаа, зөрчлийн 23,7 хувь буюу 25140.7 мянган төгрөгийн зөрчилд хохирлыг барагдуулах төлбөрийн акт тогтоож, 76,3 хувь буюу 81066,9 мянган төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.

Төрийн аудитын байгууллагаас аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил түүний шийдвэрлэлийн байдлыг дор нэгтгэн үзүүлэв. Үүнд:

(Мянган төгрөг)

№	Байгууллагын ангилал	Илрүүлэлт						Залруулга	
		Зөрчил		Алдаа		Бүгд дүн		Тоо	Дүн
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	ТТЗ	2	10000,0	-	-	2	10000,0	-	-
2	ТШЗ	6	96207,6			6	96207,6		
3	ТБӨААН	-	-	-	-	-	-	-	-
	Дүн	8	106207,6	-	-	8	106207,6		

### Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

(Мянган төгрөг)

Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТТЗ	2	10000,0	-	-	-	-	2	10000,0	-	-	-	-
2	ТШЗ	6	96207,6	3	25140,7	-	-	3	71066,9	-	-	-	-
3	ТБӨААН	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Дүн	8	106207,6	3	25140,7	-	-	5	81066,9	-	-	-	-

### 2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Өлзийт сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Өлзийт сумын Засаг даргын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС,

Өлзийт сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

Санал дүгнэлтийн хэлбэр (Тоогоор)

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлтийн хэлбэр (Тоогоор)				Дүн
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан	
1	ТШЗ	4	1	-	-	5
2	ТБООААН	-	-	-	-	-
	Дүн	4	1	-	-	5

### 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Өлзийт сумын Засаг даргын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1 Балансын данстай холбоотой асуудал

##### 3.1.1 Илрүүлэлт:

Сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд оны эхэнд үлдэгдлээр байсан авлагаас ОНХС-ийн дансанд бүртгэлтэй "Жишиг бетон" ХХК-аас авах 10,000,000 төгрөгийг барагдуулаагүй, тус ААН-тэй тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 39 дэх заалтыг зөрчсөн байна.

##### 3.1.2 Эрсдэл:

Авлага, өглөгийг барагдуулж ажиллаагүй байх

##### 3.1.3 Өгсөн зөвлөмж:

**2015 онд үүссэн "Жишиг бетон" ХХК-ний авлагын 10,0 сая төгрөгийг барагдуулах**

##### 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдааг зөвшөөрч байна. Хэрэгжүүлж ажиллана.

#### 3.2 Балансын данстай холбоотой асуудал

##### 3.2.1 Илрүүлэлт:

Сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын сургууль, цэцэрлэг, соёлын төвүүдийн дүнгээр 5889521 төгрөгийн нөөцийн бараа бүртгэлтэй байхад дээрх БНА-2019/11/СТА-ТТЗ

байгууллагуудын санхүүгийн тайланд бараа материал дансанд бүртгэж, зөрүүтэй бүртгэгдсэн байна.

Энэ нь Үнэлгээ гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг зөрчсөн байна.

### 3.2.2 Эрсдэл:

Бараа материалын ангилал буруу хийгдсэн байх

### 3.2.3 Өгсөн зөвлөмж:

**Э-тайланд нөөцийн бараа дүнгээр оруулсан 5889521 төгрөгийн бараа материалыг Э-тайланд бараа материалаар залруулах**

### 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдааг зөвшөөрч байна. Хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 05 дугаар сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>574,153,360.19</b>	<b>639,386,805.84</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	52,534,338.66	136,531,069.45
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	52,534,338.66	136,531,069.45
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	52,534,338.66	136,531,069.45
31211	Төрийн сангийн харилцах	52,534,338.66	136,531,069.45
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	232,004,832.00	179,418,185.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		1,949.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	18,725,650.00	13,706,400.00
3351	Байгууллагаас авах авлага	18,653,650.00	13,706,400.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	72,000.00	
<b>336</b>	<b>Зээлийн авлага</b>	213,279,182.00	165,709,836.00
<b>3361</b>	<b>Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага</b>	213,279,182.00	165,709,836.00
33612	Хувь хүмүүст олгосон зээл	213,279,182.00	165,709,836.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	283,724,668.53	317,548,030.39
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	187,465,234.12	201,370,639.91
35110	Тусгай зориулалттай материал	185,090,325.32	199,609,931.11
35130	Эм боох материал	2,374,908.80	1,760,708.80
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	84,349,434.41	106,177,390.48
35410	Бичиг хэргийн материал	5,436,965.00	6,302,865.00
35420	Аж ахуйн материал	23,571,108.00	28,620,382.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,102,000.00	823,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,750,000.22	33,380.00
35450	Барилгын засварын материал	2,725,180.00	3,015,980.18
35460	Хүнсний материал	82,670.52	343,300.63
35470	Бусад хангамжийн материал	49,681,510.67	67,038,482.67
35600	Мал амьтад	11,910,000.00	10,000,000.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	5,889,521.00	5,889,521.00
36600	Бусад нөөц	5,889,521.00	5,889,521.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,952,362,654.68</b>	<b>5,013,923,015.10</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,952,362,654.68	5,013,923,015.10
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,951,755,484.07	4,955,657,028.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,568,878,050.00	5,013,894,686.11
39202	Хуримтлагдсан элэгдэл	-2,194,470,879.60	-425,236,555.71
39203	Авто-тээврийн хэрэгсэл	258,406,112.00	201,051,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-123,108,131.82	-106,947,187.58
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	340,942,766.25	375,458,870.98
39206	Хуримтлагдсан элэгдэл	-263,667,580.11	-278,654,175.48
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	263,218,842.19	293,150,716.95
39208	Хуримтлагдсан элэгдэл	-141,530,723.77	-162,216,707.74
39214	Бусад үндсэн хөрөнгө	328,840,856.00	26,965,230.00

**Өлзийт сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

39215	Хуримтлагдсан элэгдэл	-119,647,464.07	
39216	Дуусаагүй барилга, байгууламж	17,400,000.00	7,400,000.00
39217	Ном	16,493,637.00	10,790,351.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>607,170.61</b>	<b>58,265,986.57</b>
39301	Програм хангамж	2,134,000.00	3,134,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,134,000.00	-2,134,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	3,311,840.00	60,301,840.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-2,704,669.39	-3,035,853.43
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>3,526,516,014.87</b>	<b>5,653,309,820.94</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>141,528.00</b>	<b>7,072,749.72</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>141,528.00</b>	<b>7,072,749.72</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>141,528.00</b>	<b>7,072,749.72</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	141,528.00	266,911.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг		6,805,838.72
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,526,374,486.87</b>	<b>5,646,237,071.22</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>3,526,374,486.87</b>	<b>5,646,237,071.22</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,966,420,387.66	2,023,410,387.66
51101	Өмч: - төрийн	1,966,420,387.66	2,023,410,387.66
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>414,305,178.69</b>	<b>947,717,176.66</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	369,813,662.63	414,305,178.69
51220	Тайлант үеийн үр дүн	44,491,516.06	533,411,997.97
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,145,648,920.52	2,675,109,506.90
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,526,516,014.87</b>	<b>5,653,309,820.94</b>

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,738,910,083.18</b>	<b>2,947,731,625.17</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>85,260,740.79</b>	<b>50,176,599.00</b>
<b>110</b>	<b>Орлогын албан татвар</b>	<b>12,840,376.79</b>	<b>11,603,354.00</b>
